

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
2026 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ**

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Хамтын гэрээний зорилго нь Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС)-ийн Үйлдвэрчний эвлэлийн гишүүн багш, ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, Хөдөлмөрийн хууль тогтоомжоор шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхэд оршино.
- 1.2 Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн ажил олгогчийг төлөөлж ШУТИС-ийн Захиргаа, ажилтныг төлөөлж Үйлдвэрчний эвлэлийн хороо (ҮЭХ) (цаашид талууд гэх) харилцан тохиролцож, энэхүү хамтын гэрээг байгуулав.
- 1.3 Хамтын гэрээ нь ШУТИС-ийн Үйлдвэрчний эвлэлийн гишүүн багш, ажилтны цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал олгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, талуудын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх харилцааг зохицуулна.
- 1.4 Энэхүү Хамтын гэрээний үйлчлэлд хамаарахгүй багш, ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр ханган, Хөдөлмөрийн хууль тогтоомжоор шууд зохицуулаагүй асуудлыг ажил олгогчийн зүгээс байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний акт, хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.
- 1.5 Хамтын гэрээ байгуулагч талуудын харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй.
- 1.6 Энэхүү гэрээ нь 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2027 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 1.7 Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талуудын аль нэг нь бичгээр хүсэлт гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор асуудлыг авч хэлэлцэнэ.
- 1.8 Их сургуулийн үйл ажиллагааны холбогдох төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулахдаа энэхүү Хамтын гэрээний хэрэгжилтийг хангахтай холбогдох арга хэмжээнүүдийг бүрэн тусгаж, шаардлагатай санхүүжилтийг тухайн санхүүгийн жилийн төсөвт тусгана.
- 1.9 ШУТИС-д дагаж мөрдөгдөх хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд гэрээнд оролцогч талууд хяналт тавьж ажиллана.

Хоёр. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нэмэгдлийн талаар

- 2.1 Багш нарын ажлын гүйцэтгэлийг ШУТИС-ийн Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журмын дагуу бүрэн тооцож, ажлын хөлсийг нь олгоно.
- 2.2 Багш, ажилтнуудын албан тушаалын үндсэн цалинг ШУТИС-ийн Ректорын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн "Цалин нэмэгдүүлэх, цалингийн сүлжээ шинэчлэн батлах тухай" А/258 дугаар тушаалаар баталсан цалингийн сүлжээний бүх албан тушаалын ангилал, зэрэглэлийн III шатлалд заасан дүнгээр тооцон, цалингийн сүлжээг Ректорын тушаалаар шинэчлэн тогтоож, 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө. Энэхүү шинэчлэн тогтоосон үндсэн цалингаас багш, ажилтны ажилласан жилийн нэмэгдлийг дараах хувиар тооцож, 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр олгоно. Үүнд:

№	Нийт ажилласан сар	Сард олгох нэмэгдлийн хувь
1	24-60 сар	үндсэн цалингийн 2 хувь
2	61-120 сар	үндсэн цалингийн 4 хувь
3	121-180 сар	үндсэн цалингийн 6 хувь
4	181-240 сар	үндсэн цалингийн 8 хувь
5	241 сараас дээш	үндсэн цалингийн 10 хувь

- 2.3 Багш нар хүрэлцээгүй, зайлшгүй тохиолдолд хичээл заасан багш нарын илүүгийн илүү цагийн хөлсийг ШУТИС-ийн Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журмын дагуу тухайн хичээлийн жилд бодож, Ректорын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Ректорын тушаалаар олгоно.

- 2.4 Нийтээр амрах баярын өдөр тасарсан хичээлийг багш нар агуулгаар нь нөхөх үүрэгтэй бөгөөд ийнхүү тасарсан хичээлийг багшийн гүйцэтгэлээс хасахгүй.
- 2.5 Багшаас бусад ажилтан тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа тохиолдолд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, Ректорын тушаалаар тогтоож олгоно.
- 2.6 Биеийн тамир, спортын тэнхимийн эрдмийн зэрэг, цолгүй багш, ажилтны спортын мастер, цолны нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар тооцон, сар бүр олгох асуудлыг тухайн багш, ажилтны хөдөлмөрийн гэрээнд тусган шийдвэрлэнэ.

Гурав. Ажил амралтын цаг

- 3.1 Ажлын цагаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан багш, ажилтныг суралцаж байх хугацаанд нь ажлын цагийг богиносгож, үндсэн цалин, урамшууллыг ажил олгогч бүрэн олгоно.
- 3.2 Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагын цагийг холбогдох хуульд зааснаар олгох бөгөөд энэхүү цагийг ажлын цагт оруулан тооцно.
- 3.3 ШУТИС-ийн багш, ажилтан Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 тоот тушаалаар баталсан журмын дагуу жил бүр ээлжийн амралтаа биеэр эдэлж, ээлжийн амралтын цалинг бүрэн авна. Ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй багш, ажилтны амралтын үлдсэн хоногийг онд нь багтаан заавал биеэр эдлүүлнэ.
- 3.4 Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй багш, ажилтныг тухайн жилд нь багтааж амруулах ба нөхөн амруулах боломжгүй бол мөнгөн урамшуулал олгоно. Ажилласан нэг өдрийн мөнгөн урамшууллын хэмжээ нь тухайн албан тушаалтны үндсэн цалингийн нэг өдрийн хөлстэй тэнцүү байна.
- 3.5 Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлэн ажиллуулах, шилжүүлэх боломжгүй бол ажилтанд үндсэн цалингийн 75 хувиар олговор олгоно.
- 3.6 Шөнийн цагаар болон нийтээр амрах баярын өдөр, долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны А/192 тоот тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг баримтлан хөлсийг бодож олгоно.

Дөрөв. Нийгмийн асуудлын талаар

- 4.1 ШУТИС-ийн багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх үлгэрчилсэн журамд заасны дагуу бүрэлдэхүүн, салбар сургууль орлогынхоо 2 хүртэлх хувийг багшийг хөгжүүлэх үйл ажиллагаанд төсөвлөж, зарцуулалтанд талууд хяналт тавина.
- 4.2 Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэрт гарах эрх нь үүссэн багш, ажилтан тэтгэвэрт гарахад нь ШУТИС-д ажилласан хугацаанаас хамааруулан (гадаадад магистр, докторт суралцсан, хувиараа чөлөө авсан хугацааг тооцохгүй) албан тушаалын үндсэн цалинтай нь тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг дараах хэмжээгээр тооцон олгоно. Үүнд:

№	ШУТИС-д ажилласан сарын тоо	Тэтгэмжийн хэмжээ	№	ШУТИС-д ажилласан сарын тоо	Тэтгэмжийн хэмжээ
1	6-24 сар	1 сарын үндсэн цалин	10	217-228 сар	10 сарын үндсэн цалин
2	25-60 сар	2 сарын үндсэн цалин	11	229-240 сар	11 сарын үндсэн цалин
3	61-120 сар	3 сарын үндсэн цалин	12	241-252 сар	12 сарын үндсэн цалин
4	121-156 сар	4 сарын үндсэн цалин	13	253-264 сар	13 сарын үндсэн цалин
5	157-168 сар	5 сарын үндсэн цалин	14	265-276 сар	14 сарын үндсэн цалин
6	169-180 сар	6 сарын үндсэн цалин	15	277-288 сар	15 сарын үндсэн цалин

7	181-192 сар	7 сарын үндсэн цалин	16	289-300 сар	16 сарын үндсэн цалин
8	193-204 сар	8 сарын үндсэн цалин	17	301-312 сар	17 сарын үндсэн цалин
9	205-216 сар	9 сарын үндсэн цалин	18	313 ба түүнээс дээш сар	18 сарын үндсэн цалин

- 4.3 Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор ШУТИС-д бусад сургуулиас шилжиж ирсэн багш тэтгэвэрт гарахад боловсролын байгууллагад ажилласан хугацаанаас нь хамааруулан, албан тушаалын үндсэн цалинтай нь тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг дараах хэмжээгээр тооцон олгоно. Үүнд:

№	Боловсролын байгууллагад ажилласан жил	Тэтгэмжийн хэмжээ
1	15-18 жил	3 сарын үндсэн цалин
2	18-21 жил	6 сарын үндсэн цалин
3	21-25 жил	9 сарын үндсэн цалин
4	25 ба түүнээс дээш жил	12 сарын үндсэн цалин

- 4.4 “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль” болон “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзлыг хангаж, өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр өмнө нь тогтоолгосон ШУТИС-д ажиллаж байгаа багш, ажилтан ажлаас чөлөөлөгдөхөд энэхүү Хамтын гэрээний 4.2, 4.3-т заасан нэг удаагийн тэтгэмжийг олгохгүй.
- 4.5 ШУТИС-д ажиллаж байгаа багш, ажилтан нас барвал нэг сарын албан тушаалын үндсэн цалинтай нь тэнцэх, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан нас барвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгоно.
- 4.6 Багш, ажилтны төрсөн эцэг эх, ах эгч дүү, нөхөр эхнэр, хүүхэд нь нас барвал 500,000 (таван зуун мянга) төгрөгийн тусламж үзүүлнэ.
- 4.7 Өөрийн амьдран суудаг гэр, орон сууц нь гал түймэр, үер усны гэх мэт давагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд гишүүн багш, ажилтанд нэг сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгоно.
- 4.8 Төрийн байгууллагад 20-иос доошгүй жил, үүнээс ШУТИС-д 10-аас доошгүй жил ажилласан профессор багш, ажилтанд ээлжийн амралтаараа магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилал, эмчилгээнд явах тохиолдолд 300,000 (гурван зуун мянга) хүртэл төгрөгийн буцалтгүй тэтгэмжийг холбогдох баримтыг үндэслэн, гурван жилд нэг удаа олгох асуудлыг ШУТИС-ийн захиргааны ажилтанд захиргааны зөвлөлийн, бусад багш, ажилтанд тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар тус тус шийдвэрлэнэ.
- 4.9 Бүрэлдэхүүн, салбар сургууль, бусад бүтцийн нэгжийн хамт олны өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулахад зориулан Горхи дахь полигонд очих, ирэх унааны зардал болон холбогдох бусад зардлыг жилд нэг удаа тухайн сургууль, нэгж хариуцан гаргана.
- 4.10 Тус их сургуульд 5-аас дээш жил хариуцсан ажилдаа идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа бакалавр, магистрын түвшинд суралцах эрхийн шаардлага хангасан ажилтны ШУТИС-д суралцахаар сонгосон мэргэжлээр нь суралцах хугацаанд нэг удаа, аль нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50 хувиар нэг удаа хөнгөлж суралцуулна.
- 4.11 ШУТИС-ийн багш, ажилтан докторын зэргийн урьдчилсан хамгаалалтаа амжилттай хийсэн бол 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгоно.
- 4.12 Багш, ажилтныг орон сууцаар хангах зорилгоор арилжааны банкууд, орон сууцны корпорац, аж ахуйн нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулж, орон сууц авах багш, ажилтныг хөнгөлөлттэй урт хугацааны зээлд хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах үүргийг ажил олгогч хүлээнэ.
- 4.13 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх холбогдох дэд зөвлөл, бүрэлдэхүүн, салбар сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр зөвшөөрөгдсөн сурах бичиг, сургалтын гарын авлагыг хэвлүүлэх, олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх эрх авсан профессор багш, ажилтанд хэвлэлтэй холбоотой

зардлыг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

- 4.14 ШУТИС-д 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа багш, ажилтан хүнд өвчин (эмнэл зүйн, лабораторийн аргаар мэргэжлийн байгууллагаар тодорхойлсон дүгнэлт)-ийн улмаас эх орондоо болон гадаад улсад 10 сая төгрөгөөс дээш төлбөртэй эмчилгээ хийлгэх тохиолдолд ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн шийдвэрээр тухайн харьяалах нэгж нь 2,000,000 (хоёр сая) төгрөг, бусад бүрэлдэхүүн, салбар сургууль, захиргаа тус бүр 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл

- 5.1 Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасны дагуу сургууль бүр төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зардлын 0.5% хүртэл хувиар тооцсон хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна.
- 5.2 Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2-т заасан үндэслэлээр ажлаас чөлөөгөдсөн багш, ажилтанд тус хуулийн 82.1-т заасан хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.
- 5.3 ШУТИС-ийн Захиргаа нь Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг Засгийн газрын 2022 оны 153 тоот тогтоолоор баталсан "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссийн дүрэм"-ийн дагуу ажиллуулна.
- 5.4 Мэргэжлийн онцлогоос хамааруулан, ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- 5.5 Хөдөлмөр хамгаалах хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн, Стандарт, хэмжил зүйн газраас тогтоосон норм, журмын дагуу хүрэлцэхүйц хэмжээгээр захиалж, хугацаанд нь олгоно.
- 5.6 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг багш, ажилтан, сургалтын мастер, архивын ажилтан (үүнд архив хариуцан ажиллаж буй албан тушаалтан хамаарна), УВЧ аппарат, парафин лаа эмчилгээ хийдэг физик эмчилгээний эмч, номын санч, бохирын слесарь, ариун цэврийн өрөөний үйлчлэгч нарт ажлын өдөр бүр хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн болох 0.5 литр сүүг олгоно. Эдгээр албан тушаалд ажиллаж буй багш, ажилтан болон бусад бүх үйлчилгээний ажилтанд харшлын сорил тавиулах ажлыг бүрэлдэхүүн, салбар сургууль, бүтцийн нэгжүүд жилд нэг удаа зохион байгуулна.
- 5.7 Үйлчилгээний ажилтанд олгох ажлын хувцас, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалын чанарыг сайжруулж, хүний биед хоргүй угаалгын бодис, цэвэрлэгээний бодисыг зохих нормын дагуу олгоно.
- 5.8 Тоостой (тоосонцортой) нөхцөлд ажилладаг номын сан, архивын болон сургалтын албаны-ажилтны ажлын байрны нөхцөлийг сайжруулж, агаар чийгшүүлэгч суурилуулж, арчих, цэвэрлэгээний материал олгоно.
- 5.9 ШУТИС-ийн хичээлийн байруудыг жилд 2 удаа ариутгаж, халдваргүйжүүлэлт, мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- 5.10 Багш, ажилтны ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, хичээл зааж буй анги танхимийн агааржуулалт, эрүүл ахуй, галын аюулгүй байдлыг хангана. Подвалд байрлаж байгаа багш, ажилтны өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт зэргийг эрс сайжруулж, стандарт хэмжээнд хүргэх арга хэмжээ авна.
- 5.11 ШУТИС-ийн хичээлийн байрны ариун цэврийн өрөөний тохижилтыг сайжруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гар угаах шингэн саван, ариутгагч уусмал, гар хатаагч, багш нарын өрөө болон коридорт ус цэвэршүүлэгч зэргийг байршуулна.
- 5.12 ШУТИС-ийн хичээлийн байруудад байрлах цайны газрын тохижилт, хоолны чанар, ариун цэврийг дээшлүүлж, тогтмол ажиллагаатай болгох үүргийг ажил олгогч хүлээнэ.
- 5.13 Холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн ШУТИС-ийн багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулна. Эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг 1 хүнд 40,000 (дөчин мянга) төгрөгөөр тооцон, ажил олгогч хариуцаж гаргана. Хэрэв ажил олгогч эрүүл мэндийн үзлэгт тухайн жилд хамруулж чадаагүй бол дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан хамруулах бөгөөд санхүүжилтийг шийдвэрлүүлнэ.

Зургаа. Талуудын хамтын ажиллагаа

- 6.1 Багш, ажилтны мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ажил олгогч Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран, жилд нэгээс доошгүй удаа багш, ажилтанд зориулан төрөл бүрийн сургалт зохион байгуулна.

- 6.2 Үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуультанд тухайн сонгуульт ажилтай нь холбогдуулан, сахилгын шийтгэл ногдуулах, хэлэлцээрт оролцсоных нь төлөө өөр ажилд шилжүүлэх, ажил олгогчийн санаачилгаар хэлэлцээний туршид болон хэлэлцээ дууссанаас хойш нэг жилийн дотор ажлаас халахыг хориглоно.
- 6.3 ШУТИС-ийн Удирдах зөвлөл, Ректорын зөвлөл, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнд Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөллийг оруулна.
- 6.4 Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татварыг цаг тухайд нь тухайн салбар хороодын данс руу бэлэн бусаар хурааж шилжүүлэх үүргийг бүрэлдэхүүн, салбар сургууль, бусад бүтцийн нэгж хүлээнэ.
- 6.5 Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөллийг дараах комисс, зөвлөлийн үйл ажиллагаанд заавал ажиллуулна. Үүнд:
- ✓ Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс,
 - ✓ Үйлдвэрийн ослын шалтгаан тогтоох комисс,
 - ✓ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл.
- 6.6. Хөдөлмөрийн харилцаа, Боловсролын салбарын хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, танин мэдүүлэх тал дээр гэрээнд оролцогч талууд хамтран ажиллана.

Долоо. Гэрээний биелэлтийг хянах, мэдээлэх

- 7.1 Их сургуулийн захиргааны зүгээс багш, ажилтны санал хүсэлтийг жилд нэг удаа нэгдсэн журмаар сонсож, Хамтын гэрээний биелэлт, хэрэгжилтийн талаар мэдээлнэ.
- 7.2 Талууд гэрээний хэрэгжилттэй холбоотой өөрт байгаа бүх мэдээллийг нээлттэй солилцоно.
- 7.3 Хамтын гэрээний хэрэгжилтэд талууд хяналт тавина.
- 7.4 Хамтын гэрээг биелүүлэх явцад үүссэн саналын зөрүүтэй асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ажил олгогчийг төлөөлж:

ШУТИС-ийн санхүү, төлөвлөлт эрхэлсэн
проректор

.....В.Өлзийбаяр

МИТС-ийн захирал

.....Н.Пүрэвдорж

ХХҮДС-ийн захирал

.....Н.Ганзориг

ЭХИС-ийн захирал

.....Бя.Бат-Эрдэнэ

Захиргааны удирдлагын газрын ахлах
мэргэжилтэн

.....С.Пүрэвдулам

Ажилтныг төлөөлж:

ШУТИС-ийн дэргэдэх ҮЭХ-ны дарга

.....С.Дэлгэрмаа

Захиргааны ҮЭ-ийн салбар хорооны дарга

.....Ц.Сэрчмаа

ГУУС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга

.....П.Лувсандагва

ХХҮДС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга

.....Х.Мөнхзаяа

ЭХИС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга

.....А.Түмэнбаяр

НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2006 . 03 13 ны өдөр